



БАЯНХОНГОР АЙМАГ  
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/14

Хөхбүрд

Малчид, төлчид, тариаланчдын зөвлөгөөн  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6, Сумын засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн сумын “Шилдэг хот айл” шалгаруулах журмын 2.1.16, 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн “Шилдэг холбоо” шалгаруулах журмын 3.1.6 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малчид, төлчид, тариаланчдын талаар төрөөс авч хэрэгжүүлж байгаа ажил үйлчилгээг сурталчилан танилцуулах мэдээ мэдээлэлээр хангах, ажлын арга барил, туршлага солилцуулах, малчдын санал хүсэлт сонсож сум орон нутгийн бодлого шийдвэрийг тусган хэрэгжүүлэхээр малчид, төлчид, тариаланчдын зөвлөгөөнийг 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсугай.

2. Засаг даргын нөөц хөрөнгөөс 14.474.000 (Арван дөрвөн сая дөрвөн зуун далан дөрвөн мянган) төгрөгийг санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Жавзансүрэн), Нягтлан бодогч (Л.Алимаа) нарт даалгасугай.

3. Зөвлөгөөн зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, Шилдэг хот айлаар шалгаруулсан малчдын нэрс, шилдэг холбооны шагналыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

4. Дээрх ажлыг чанартай зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Орлогч дарга (Г.Ганцоож) -д үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.ХАТАНБААТАР

642201181

Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын  
06-ны өдрийн 4/14 дүгээр захирамжийн  
нэгдүгээр хавсралт

**МАЛЧИД, ТӨЛЧДИЙН, ТАРИАЛАНЧДЫН ЗӨВЛӨГӨӨН  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

**Мандалхайрхан 1 дүгээр баг**

Т.Цэцэгсайхан (Мандалхайрхан 1 дүгээр багийн Засаг дарга)  
П.Мөнхтогоо (Байгаль орчны хяналтын Улсын Байцаагч)  
Ё.Лхагвасүрэн (Дотоод ажилтан)

**Уранхайрхан 2 дугаар баг**

С.Энх-Амгалан (Уранхайрхан 2 дугаар багийн Засаг дарга)  
Г.Ууганжаргал (Татвар хураагч)  
Б.Должинсүрэн (Хөдөлмөр халамжийн мэргэжилтэн)

**Асгамба 3 дугаар баг**

М.Сэр-Од (Асгамба 3 дугаар багийн Засаг дарга)  
Л.Гүндцамба (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)  
Д.Отгонцэцэг (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

**Мэргэн 4 дүгээр баг**

Б. Дагдансүрэн (Мэргэн 4 дүгээр багийн Засаг дарга)  
Ө.Ариунзаяа (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)  
Э.Мөнхэрдэнэ (Сан хариуцсан нягтлан бодогч)

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Засаг даргын... оны... дугаар сарын  
...-ны өдрийн... дүгээр захирамжийн  
хоёрдугаар хавсралт

ШИЛДЭГ ХОТ АЙЛААР ШАЛГАРУУЛСАН  
МАЛЧДЫН НЭРС, ШИЛДЭГ ХОЛБООЧДЫН НЭРС

Д/д	Өрхийн тэргүүний овог нэр	Регистер	Баг	Мөнгөн дүн
1	2	3	4	5
Шинээр гар худаг гаргасан				
1	Д.Сэрдамба	ВГ72100911	Уранхайрхан 2 дугаар баг	2 000 000
Худаг сэргээн засварласан				
2	Ц.Ууганбаатар	ВГ81011316	Уранхайрхан 2 дугаар баг	1 000 000
Шинээр хашаа хороо барьсан				
3	Г.Дэлгэрдалай	ВГ84040911	Уранхайрхан 2 дугаар баг	2 000 000
4	С.Чулуундорж	ВГ75020411	Уранхайрхан 2 дугаар баг	2 000 000
5	Т. Долгорсүрэн	ВО58090807	Мэргэн 4 дүгээр баг	2 000 000
Шилдэг холбоо				
6	Гуахайрханы хурд ММСУХ			3 000 000
Нийт дүн				12 000 000

оОо